



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 15

Арвайхээр

Г “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” Г
орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай
компани байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 ж, 20 дугаар зүйлийн 20.1 Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулсугай.

2. “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.



О.ПҮРЭВДОРЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний
өдрийн 12 дугаар тогтоолын хавсралт



**“ӨВ АГРО ГУРИЛ ТЭЖЭЭЛИЙН ҮЙЛДВЭР”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрэм нь “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани (цаашид “Компани” гэх)-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон эрх зүйн үндсэн баримт бичиг мөн.

1.2. Компани нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн хууль, Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тогтоол шийдвэр, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээдэг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, санхүүгийн тайлан гаргадаг, ашгийн төлөө хуулийн этгээд мөн.

1.4. Компани нь 100 хувь орон нутгийн өмчит бөгөөд 1 (нэг) хувьцаа эзэмшигчтэй хуулийн этгээд болно.

1.5. Компанийн оноосон нэр нь “Өв агро гурил тэжээлийн үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компани, товчилсон нэр нь “Өв агро ГТҮ” ХХК болно.

1.6. Компанийн байршил нь түүний гүйцэтгэх удирдлагын байрлаж буй хаягаар тодорхойлогдох бөгөөд хаягийн өөрчлөлтийг компанийн гүйцэтгэх удирдлага тухай бүр улсын бүртгэлд бүртгүүлнэ.

1.7. Компани нь өөрийн бэлгэдэл, барааны тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, өөрийн нэр бүхий тэмдэг тус тус хэрэглэнэ.

1.8. Төлөөлөн удирдах зөвлөл компанийн бэлгэдэл, тэмдэг, барааны тэмдгийн загварыг баталж, Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлсэн байх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн компани эдэлнэ.

1.9. Компанийн тэмдгийг компанийн гүйцэтгэх удирдлага, эсвэл компанийн гүйцэтгэх удирдлагаас итгэмжлэн хариуцуулсан этгээд хадгалж, зохих журмын дагуу хэрэглэнэ.

ХОЁР. КОМПАНИЙН ҮНДСЭН ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

2.1. Компанийн үндсэн зорилт нь гурил, малын тэжээлийг орон нутагтаа үйлдвэрлэх, борлуулах, чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулж, орон нутгийн өмчийн өгөөжийг нэмэгдүүлэн, ашигт ажиллагааг хангахад оршино.

2.2. Компани нь дор дурьдсан үйл ажиллагаа явуулна:

2.2.1 Гурил үйлдвэрлэх;

2.2.2 Малын тэжээл үйлдвэрлэх;

2.3. Компани нь үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ нийцүүлэн хууль тогтоомжоор хориглоогүй, бусад үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг компанийн хувьцаа эзэмшигч гаргана.

2.4. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрлийг авна.

2.5. Компанийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан журмын дагуу тогтооно.

2.6. Компани нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

2.7. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагааг Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу явуулна.

ГУРАВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА

3.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Компанийн тухай хуулийн 30.1 дэх хэсэгт зааснаар тодорхойлно.

3.2. Компанийн дүрмийн сан 1.0 сая /нэг сая/ төгрөг байна.

3.3. Компанийн өөрийн хөрөнгө хувьцаанаас бүрдэх бөгөөд нэг бүр нь 10,000 /Арван мянган/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 /нэг зуу/ ширхэг энгийн хувьцаатай байна. Хувьцааны үнэ, тоо хэмжээнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хувьцаа эзэмшигч шийдвэрлэнэ.

3.4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчийн шийдвэрт үндэслэн өөрчилж болно.

3.5. Энэхүү дүрмийн 3.4 заасан үйл ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ

4.1. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг Төлөөлөн Удирдах Зөвлөл гаргана.

4.2. Аймгийн Засаг дарга нь ногдол ашиг хуваарилах, ногдол ашгийн хэмжээний талаар саналаа Төлөөлөн удирдах зөвлөлд бичгээр гаргаж болно.

4.3. Ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлд тавигдсан нөхцөлийг хангасан тохиолдолд ногдол ашиг хуваарилна.

4.4. Хуваарилсан ногдол ашгийг Өвөрхангай аймгийн төсөвт төвлөрүүлнэ.

4.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчид тухай бүрт заавал тайлагнана.

ТАВ. КОМПАНИЙН УДИРДЛАГА

5.1.1 Компанийн удирдлага дараах бүтэцтэй байна.

- 5.1.1. Хувьцаа эзэмшигч;
- 5.1.2. Төлөөлөн Удирдах Зөвлөл;
- 5.1.3. Гүйцэтгэх удирдлага;

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

6.1. Компанийн хувьцаа эзэмшигч нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид “хувьцаа эзэмшигч” гэх/ байна.

6.2. Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Хувьцаа эзэмшигчийн нэрийн өмнөөс компанийн гүйцэтгэх удирдлагыг аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

6.3 Хувьцаа эзэмшигч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 6.3.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 6.3.2. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
- 6.3.3. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- 6.3.4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийг томилох, чөлөөлөх;
- 6.3.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг батлах;
- 6.3.6. Ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
- 6.3.7. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, олгох цалин, урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тусгасан гэрээний нийтлэг загварыг батлах;
- 6.3.8 Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх, холбогдох шийдвэр гаргах;
- 6.3.9 Компанийн тухай хуульд заасан бусад асуудал.

6.4. Хувьцаа эзэмшигч-аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь өөрийн баталсан дэгийн дагуу хуралдаанаа зохион байгуулна.

ДОЛОО. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

7.1 Хувьцаа эзэмшигчийн чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл байна.

7.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаагаа хувьцаа эзэмшигчийн өмнө хариуцна.

7.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хуралдаан нь жилд 2-оос доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.

7.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдааны шийдвэр нь тогтоол байх бөгөөд түүнд Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

7.5 Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүнийг 4 жилийн хугацаатайгаар томилно.

7.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүн нь Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

7.7 Компанийн ТУЗ-д төрийг төлөөлөн оролцож буй гишүүн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан эрх хэмжээний хүрээнд ажиллана.

7.8 Төлөөлөн Удирдах Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

7.8.1. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, бодлогыг тодорхойлох;

7.8.2. Компанийн бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

7.8.3. Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах;

7.8.4. Компанийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн бодит үнийг тогтоох;

7.8.5. Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах;

7.8.6 Хувьцаа эзэмшигчээс баталсан гэрээний нийтлэг загварт үндэслэн гүйцэтгэх захиралтай харилцан тохиролцож гэрээг байгуулан, аймгийн Засаг даргаар батлуулах;

7.8.7. Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;

7.8.8. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчид танилцуулж, батлуулах;

7.8.9. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

7.8.10. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлах.

7.8.11. Эрх бүхий мэргэжлийн байгууллагуудаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх талаар гүйцэтгэх удирдлагад шаардлага тавьж, биелэлтийг хангуулах;

7.8.12. Хуульд заасан бусад эрх.

7.9. Энэхүү дүрмийн 7.8.4, 7.8.6, 7.8.8–д заасан асуудлыг хэлэлцэхэд Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд заавал оролцож саналаа өгнө.

7.10. Компанийн менежемент, ашигт ажиллагааг дээшлүүлэх зорилгоор өндөр ур чадвар бүхий иргэнийг контракт байгуулж, гүйцэтгэх захирлаар ажиллуулахаар аймгийн Засаг даргад санал оруулж болно.

7.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг Компанийн тухай хууль, хувьцаа эзэмшигчээс баталсан Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам болон энэхүү дүрмээр зохицуулна.

НАЙМ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

8.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон түүнтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь компанийн гүйцэтгэх захирал байна.

8.2. Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн Удирдах Зөвлөл сонгон шалгаруулж, аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

8.3. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

8.4. Гүйцэтгэх захирал нь компанийн ерөнхий инженер, ерөнхий нягтлан бодогчийг томилох, чөлөөлөх асуудлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй зөвшилцөнө.

8.5. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбогдож үүссэн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх тохиолдолд хувьцаа эзэмшигчээс томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийг төлөөлөн оролцоно.

8.6. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна. Үүнд;

8.6.1. Менежментийн ур чадвартай, 3-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажил гүйцэтгэж байсан, удирдлагын зохих туршлагатай, дээд боловсролтой байх;

8.6.2. Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

8.6.3. Ял шийтгэлгүй байх;

8.6.4. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

8.7. Гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ. Үүнд;

8.7.1. Төлөөлөн удирдан зөвлөлийн өмнө Компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд хоёроос доошгүй удаа ажлын үр дүн, гэрээний үүргийн биелэлтийг тайлагнан дүгнүүлэх;

8.7.2. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

8.7.3. Компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар батлуулж, түүний хэрэгжилтийг зохион байгуулах;

8.7.4. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний Тэргүүлэгчид болон аймгийн Засаг дарга, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

8.7.5. Компанийн нэр хүнд, ашиг, орлого, хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, санхүү болон бусад үйл ажиллагааг алдагдал, эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн удирдлагын оновчтой менежментийг нэвтрүүлэх;

8.7.6. Батлагдсан төсөв, хөрөнгийг өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах;

8.7.7. Батлагдсан төсвийн хүрээнд албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн сүлжээг баталж мөрдүүлэх, цалин хөлс, тэтгэмж, хөнгөлөлт, урамшуулал олгох;

8.7.8. Компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийг удирдах;

8.7.9 Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

8.7.10. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, цуцлах, дуусгавар болгох;

8.7.11. Компанийн дотоод үйл ажиллагаатай холбогдох хөдөлмөрийн дотоод журам, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны журам, бусад холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

8.7.12. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;

8.7.13. Компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх, үндсэн хөрөнгийн асуудлыг Орон нутгийн өмчийн газарт танилцуулан шийдвэрлүүлэх;

8.8 Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас олгосон зөвшөөрлийн дагуу зарим эрх, үүргээ итгэмжлэлийн үндсэн дээр компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

ЕС. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

9.1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх захирал, ерөнхий инженер, ерөнхий нягтлан бодогчийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

9.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн дүрэмд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

9.3. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын асуудлыг компанитай байгуулсан гэрээ, компанийн дотоод журмаар тогтоох бөгөөд байгуулсан гэрээ, тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

9.4. Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд зааснаар үүрэг, хариуцлага хүлээнэ.

АРАВ. КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

10.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

10.1.1. Хувьцаа эзэмшигчийн хяналт;

10.1.2. Хөндлөнгийн аудит;

10.1.3. Дотоод хяналт;

10.2. Хувьцаа эзэмшигчийн хяналтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний харъяа хяналт, дотоод аудитын чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагууд хэрэгжүүлнэ.

10.3. Энэхүү дүрмийн 10.2-т заасан мэргэжлийн байгууллагууд хяналт, шалгалт, дотоод аудитын тайланг аймгийн Засаг даргад танилцуулна.

10.4. Хөндлөнгийн аудитыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн сонгосон тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар хийлгэнэ.

10.5. Хөндлөнгийн аудитын тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчид танилцуулна.

10.6. Компанийн дотоод хяналтыг Гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын нэгж /ажилтан/ хэрэгжүүлнэ.

10.7. Дотоод хяналтын нэгж /ажилтан/ нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг туршлагатай байх бөгөөд Гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

10.8. Дотоод хяналтын нэгж /ажилтан нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх удирдлагад өгөх, Төлөөлөн Удирдах зөвлөлд танилцуулах, мэдээлэх үүрэгтэй.

АРВАН НЭГ. ИХ ХЭМЖЭЭНИЙ БОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

11.1. Их хэмжээний хэлцэл гэж тухайн хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 87, 88 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

11.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 89, 91, 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

11.3. Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн энэхүү дүрмийн 11.1, 11.2-т заасан хэлцлийн талаарх мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

АРВАН ХОЁР. КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАН

12.1. Компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй байна.

12.2 Компани нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан Хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулах бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч хариуцна.

12.3. Компани нь хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулсны дараа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу жилийн санхүүгийн тайлан, ашиг ба алдагдлын тайлангаа компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон холбогдох хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээдэд танилцуулна.

12.4. Компанийн санхүүгийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-нээс эхэлж 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болно.

АРВАН ГУРАВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

13.1. Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.

13.2. Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

13.2.1. Баланс;

13.2.2. Үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;

13.2.3. Мөнгөн гүйлгээний тайлан;

13.2.4. Хуримтлагдсан ашиг;

13.2.5. Өмчийн өөрчлөлтийн тайлан;

13.2.6. Тухайн тайлангийн хугацаанд байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр, төрөл, үнийн дүнгийн хамт;

13.2.7. Нэмэлт тайлбар, тодруулга;

13.2.8. Санхүүгийн тайлангийн тодруулга;

13.2.9. Эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин, урамшууллын дүн, албан тушаалтан нэг бүрээр гаргах;

13.2.10. Хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл.

13.3. Санхүүгийн тайланг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас томилогдсон хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулах бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөл санхүүгийн тайланг хурлаараа хэлэлцэнэ.

АРВАН ДӨРӨВ. КОМПАНИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХАДГАЛАХ

14.1. Компани нь дараах бичиг баримтыг хадгалах үүрэгтэй:

14.1.1. Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн тэмдэг, бэлгэдлийн эх загвар;

14.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагаас баталсан компанийн дотоод баримт бичиг;

14.1.3. Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг;

14.1.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Гүйцэтгэх удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, Компанийн гүйцэтгэх захирлын тушаал, байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй бусад гэрээ, түүний биелэлттэй холбогдох баримт бичиг;

14.1.5. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, контракт болон хөдөлмөрийн гэрээ;

14.1.6. Аудитын дүгнэлт;

14.1.7. Эрх бүхий албан тушаалтан болон нийт ажилчдад олгосон цалин, урамшуулал, шагналтай холбоотой бичиг баримт;

14.1.8. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо;

14.1.9. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;

14.1.10. Бусад баримт бичиг.

14.2. Компани нь өөрийн дүрэм, тэмдэг, түүнд орсон нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг байнга хадгална. Бусад баримт бичгийг 5 жилийн хугацаатай хадгалах бөгөөд баримт бичгийн хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.

14.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурал, компанийн хувьцаа болон үнэт цаас гаргах, компанийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлттэй холбогдол бүхий баримт бичгийг хүлээн авах, хадгалах, танилцуулах, архивт шилжүүлэх ажиллагааг архив, бичиг хэргийн ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

14.4. Компанийн талаарх мэдээлэл, компанийн нэгдмэл сонирхолтой этгээд түүнтэй холбогдох мэдээлэл авах асуудлыг Компанийн тухай хуулийн 98, 99 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

АРВАН ТАВ. КОМПАНИЙГ ТАТАН БУУЛГАХ

15.1. Компанийг Иргэний хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгана.

15.2. Татан буулгах комисс томилогдсоноор Компанийн гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

АРВАН ЗУРГАА. БУСАД

16.1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

16.2. Энэхүү дүрэм болон түүнд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох бөгөөд үндсэн эхийг компани дээр хадгална.

16.3. Энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь энэхүү дүрмийн 16.2-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэхүү дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

---ooOoo---